



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
E-мэйл: dundgov@audit.gov.mn

2020. 07. 30

№

107

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Дундговь аймгийн Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Иргэний хөдөлгөөний нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аudit MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аudit MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аudit стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“Дундговь аймгийн Монгол ардын нам”-ын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дундговь аймгийн Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт . 11 . хуудастай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ТӨВСАНАА

0012029495



2020 ОНЫ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ
АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: дундговийнхoo хөгжлийн төлөө хүчээ нэгтгэе

МАНДАЛГОВЬ ХОТ

2020.0Н

A handwritten signature in blue ink, appearing to read "Мандалговь".

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: **ДУНДГОВИЙНХОО ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ , ХҮЧЭЭ НЭГТГЭЕ**

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Монгол Ардын Намын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх “БАЯЛАГ БҮТЭЭГЧ ДУНДГОВЬ”-ийг бүтээхээр мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 28 дэд бүлэг, 115 зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

НЭГ.ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1 Эрүүл иргэн
- 1.2 Боловсролтой иргэн
- 1.3 Үндэсний өв, соёл урлагыг дэмжигч иргэн
- 1.4 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн
- 1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлэх
- 1.6 Ажилтай, орлоготой иргэн
- 1.7 Залуучуудын хөгжлийг дэмжинэ
- 1.8 Ахмадын хөгжлийг дэмжинэ.
- 1.9 Нийгмийн хамгаалалын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ.
- 1.10 Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба
- 2.2 Хүнд сурталгүй -цахим Дундговь
- 2.3 Шилэн тендерийг зохион байгуулна.
- 2.4 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.
- 2.5 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

- 3.1 Малчдын амьжиргааг сайжируулна.
- 3.2 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 3.3 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.
- 3.4 Бэлчээрийн менежментийг сайжруулна.
- 3.5 Хүнсний болон газар тариаланг дэмжинэ

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ
- 4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.
- 4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл
- 4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжируулна.



ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

- 5.1 Эдийн засгийн үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 5.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.
- 5.3 Хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгана
- 5.4 Сумдад хийгдэх хөрөнгө оруулалт

НЭГ.ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл иргэн.

- 1.1.1 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Аймгийн 100 ортой нэгдсэн эмнэлгийн шинэ барилгыг ашиглалтад оруулж, шаардлагатай сумдын эрүүл мэндийн төвийн барилгыг засварлах буюу шинээр барина.
- 1.1.4 Эмнэлгийн авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.1.5 Иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.1.6 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

1.2.Боловсролтой иргэн

- 1.2.1 Олон улсын жишигт нийцсэн ЕБС, дотоодын их дээд сургуулийн салбар байгуулна.
- 1.2.2 “Багшийн хөгжлийн төв”-ийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.3 Аймгийн хэмжээнд цэцэрлэгийн барилгуудыг бүрэн шинэчилж дуусгана
- 1.2.4 “Байгалийн ухаан” болон “Математик”, “Англи хэл”, “Оюунлаг Дундговь” дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, төрөлжсөн олимпиадыг улс болон бүсийн хэмжээнд тогтмол зохион байгуулна.
- 1.2.5 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.
- 1.2.6 Зарим сумдын ерөнхий болосролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг засварлах буюу шинээр барина.

1.3 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн

- 1.3.1 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгыг ашиглалтад оруулна.
- 1.3.2 Мандалговь хотод “Палеонтолог”-ийн музей байгуулна.



1.3.3 "Уртын дууч, морин хуурчдын"-II их наадмыг зохион байгуулна.

1.3.4 Жил бүр соёл, урлагийн шилдэг ажилчдыг шалгаруулж гадаад, дотоодын арга хэмжээнд туршлага судлуулах, нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.

1.4 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн

1.4.1 Мандалговь хотод усан бассейн бүхий спорт цогцолборыг /1000-аас доошгүй суудалтай / барьж ашиглалтад оруулна.

1.4.2 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, явган алхах, дугуй унах зориулалтын зам талбайтай болгоно.

1.4.3 Багш нарын дунд урлаг, спортын их наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

1.4.4 Дундговь аймгийн "Бага Олимп" спортын наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

1.4.5 Улс, бүсийн аварга шалгаруулах үндэсний болон олимпиийн төрлийн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.

1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлэх

1.5.1 "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

1.5.2 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.5.3 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд хэрэгцээт үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж нийтийн эзэмшлийн барилга талбайд зориулалтын зам, шатыг суурилуулна.

1.5.4 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид санхүүгийн урамшуулал олгож, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэнийг ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх, төлбөрийн хэмжээ, төрийн байгууллагын удирдах ажилтны хариуцлагыг нэмэгдүүлнэ.

1.6 Ажилтай, орлоготой иргэн

1.6.1 Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.6.2 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.6.3 Их дээд болон мэргэжлийн сургууль төгссөн залуучуудыг орон нутагтаа ажиллах боломж нөхцлөөр хангана.

1.6.4 Зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран ажлын байраар хангана.

1.7 Залуучуудын хөгжлийг дэмжинэ

- 1.7.1 Гарааны бизнес эрхлэгч оюутан залуучуудад бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.7.2 Гэр бүл, хүүхэд, оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин төвүүдийг бий болгоно.
- 1.7.3 Орчин үеийн стандартад нийцсэн кино театрын барилгын ажлыг эхлүүлнэ.
- 1.7.4 Оюутан, Залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7.5 Дундговь аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулна.

1.8 Ахмадын хөгжлийг дэмжинэ

- 1.8.1 Ахмад настны мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлсэн “Ахмадын хөгжлийн ордон”-ы барилгын ажлыг дуусгана.
- 1.8.2 Хөдөлмөрийн чадвартай ахмадуудын орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.8.3 Ахмадын урлаг, спортын наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.
- 1.8.4 “Ахмад настны хөгжил хамгааллын үндэс”-ний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.9 Нийгмийн хамгаалалын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ

- 1.9.1 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг чанаржуулна.
- 1.9.2 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусlamж үйлчилгээ авах “Цахим карт” бий болгоно.
- 1.9.3 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.10. Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

- 1.10.1 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, хурд сааруулагч, гэрлэн дохио, камертай болгоно.
- 1.10.2 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчинг бүрдүүлнэ.
- 1.10.3 Эмэгтэйчүүдийн товлолт дархлаажуулалтыг нэвтрүүлж умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах “Энх Бүсгүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.10.4 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэднийг хамгаалах “Бүсийн хамгаалах төв”-н үйл ажиллагааг чанаржуулна.
- 1.10.5 Сайнцагаан суманд Ясли ажилуулах эхлэлийг тавина.



ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба

- 2.1.1 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг хадгалана.
- 2.1.2 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг улам дээшлүүлж шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.
- 2.1.3 Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 2.1.4 Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг өнөөгийн суурь түвшиний судалгаанд үндэслэн боловсруулж гүйцэтгэл, үр дүнд суурилсан “МЕРИТ” төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.5 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд багийн засаг дарга нарыг сургаж дадлагажуулан, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

2.2 Хүнд сурталгүй -цахим Дундговь

- 2.2.1 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.2 Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем “mgov.erp.mn” –г шинээр нэвтрүүлэнэ.
- 2.2.3 Цахим засаглал бодлогын хүрээнд “Дан” “Хур” цахим системийг бүх сумдад нэвтрүүлнэ.
- 2.2.4 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.
- 2.2.5 “Мандалговь хот”-ын удирдлагын төвийг бий болгоно.

2.3 Шилэн тендерийг зохион байгуулна.

- 2.3.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.
- 2.3.2 Аймаг сумын бүх төрийн байгууллагуудын “шилэн данс”-ыг хөтлөлтийг үргэлжүүлнэ.

2.4 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.

- 2.4.1 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.
- 2.4.2 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.
- 2.4.3 Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтлах, ашигт малтмалын хайгуул, ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны улмаас эвдэrsэн газрын нөхөн сэргээлтийг жилд 50 га-аас доошгүй хийлгэх.

2.4.4 Бичил уул уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлнэ.

2.5 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.1 Аймаг сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.5.2 Мандалговь хотын ундны усны эх үүсвэрийг өргөтгөх ажлыг эхлүүлнэ.

2.5.3 Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.5.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

2.5.5 Мандалговь хотод хог хаягдлыг ангилан ялгах үйлдвэр шинээр барьж, сумдын хог хаягдлын менежментийг сайжруулна.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

3.1 Малчдын амьжиргааг сайжруулна.

3.1.1 Монгол малын махыг олон улсад сурталчлан таниулж “Дундговийн мах”, “Дундговийн айраг” “Дундговийн ингэний хоормог” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.2 Малчдын орлогыг тогтвортой байлгахад анхааран “Ноолуур” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.1.3 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх” Илгээлтийн эзэн-III” аяныг хэрэгжүүлнэ.

3.2 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.2.1Өндөршил адуу, Сайнцагаан хонь, Олдохын хүрэн бор тэмээ зэрэг нутгийн брэнд цөм сүргийн тоо толгойг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

3.2.2 Эрдэнэдалай сумын “ширгүүн.govийн хонь”-ийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлаж баталгаажуулна.

3.2.3 “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимиийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

3.3 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.

3.3.1Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах, бүх багийг мал угаах ванн-тай болгож бог малыг 100 хувь хамруулна.


3.3.2 Мал эмнэлгийн шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо техникчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэж хөдөө, орон нутагт ажилуулна.

3.3.3 Мал эмнэлэг үржлийн тасгийн үйл ажиллагааг дэмжиж машин техник хэрэгслээр хангаж халдварт болон бусад өвчлөлийг бууруулна.

3.3.4 Зохиомол хээлтуүлгийн аргаар “Сайнцагаан хонь” цөм сүргийн тоог нэмэгдүүлнэ.

3.4 Бэлчээрийн менежментийг сайжруулна.

3.4.1Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж бэлчээрт гүн өрмийн худаг жилд 10-аас доошгүй, энгийн уурхайн худаг 30-аас доошгүйг сэргээн засварлах буюу шинээр гаргана.



A handwritten signature in black ink, likely belonging to the Prime Minister of Mongolia.

3.4.2 Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготонотой байгальд халгүй энгийн механик арга болон микробиологийн аргыг хослуулан тэмцэж бэлчээрийг хамгаална.

3.4.3 Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулна.

3.5 Хүнсний болон газар тариаланг дэмжинэ

3.5.1 Хүлэмжийн аж ахуй / дөрвөн улирлын хулэмж, зоорь/-гг хөгжүүлэх замаар хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ.

3.5.2 Аймгийн төв болон зарим суманд усжуулалтыг нэмэгдүүлж чацаргана, төмс, хүнсийн ногоо тариалах хувь хүн ,аж ахуйн нэгжийг дэмжинэ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ

4.1.1 Сайнцагаан, Эрдэнэдалай, Говь-Угтаал зэрэг сумдад мах, сүү, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна.

4.1.2 Орон нутгийн онцлогтой брэнд хүнсийг дотоод, гадаадын зах зээлд гарах нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг сүм болгонд байгуулахыг дэмжинэ.

4.1.3 Мандалговь хот болон сумдад өөрсдийн онцлогт нь нийцсэн жижиг дунд үйлдвэр байгуулна.

4.1.4 Мандалговь хотод жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан бизнес инкубатар төв байгуулна.

4.1.5 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, болон дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалгааг тогтмол зохион байгуулна.

4.1.6 "Пассив" хаусын үйлдвэрийг хөгжүүлнэ.

4.1.7 "Гумен"-ий үйлдвэрийг хөгжүүлж газар тариалан, хөдөө аж ахуйд нэвтрүүлнэ.

4.1.8 Хуурай баилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.

4.2.1 "Их газрын чулуу", "Бага газрын чулуу", "Цагаан суварга" зэрэг аялал жуулчлалын төвийг байгуулж орон нутгийн аялал жуулчлалын сүлжээг олон улсын аялал, жуулчлалын бүстэй холбоно.

4.2.2 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээ / Айрагны баяр, тэмээний баяр, Ардын урлагын наадам г.м-/г сурталчлах эвент арга хэмжээг тогтолжуулна.

4.2.3 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин орлогыг нь нэмэгдүүлэх.

4.2.4 Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4.3 Төр, хувийн хэвшилийн түншлэл

4.3.1. БНХАУ, ОХУ, Өмнөд Солонгос, Япон, Чех зэрэг улс орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлнэ.



4.3.2 Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын “Discover Dundgovi” зөвлөгөөнийг зохион байгуулна.

4.3.3 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлд хөрөнгө оруулалт санхүүжилт татан бичил бизнес эрхлэгч нарыг дэмжих хөтөлбөр боловсруулна.

4.3.4 “Дундговь түншлэл” арга хэмжээг жил бүр зохион байгуулна

4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжируулна.

4.4.1 Аймгийн хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачлагыг бүрэн дэмжинэ.

4.4.2 Олон улсын жишиг стандартад нийцүүлэн сүлжээ ресторан байгуулах ажлыг эхлүүлнэ.

ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

5.1 Эдийн засгийн үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

5.1.1 Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замыг шинээр барих ажлыг эхлүүлэх

5.1.2 Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замыг шинэчлэн засварлна.

5.1.3 Мандалговь хотод дулааны станцыг шинээр барьж, Баянжаргалан, Хулд, Луус сумдыг төвлөрсөн халаалттай болгоно.

5.1.4 3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг дуусгана.

5.1.5 Мандалговь хотын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамж / 0.6 кв болон 0.4кв-ын хуваарилах сүлжээ/-р бүрэн хангана.

5.2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.

5.2.1 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай сууцаар хангана. Үүнд:

а Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл-500

б. Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл-800

в. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, шинээр барих төсөл-150

г. Түрээсийн орон сууц-250

5.2.2 Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

5.2.3 Аймаг сумдад “Шинэ Гудамж”, “Шинэ хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.2.4 Аймгийн төвийн 8.1 км бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлнэ.

5.2.5 Мандалговь хот болон сумдын айл өрхийн нүхэн жорлонг “Эко нойл” болгоно.

5.2.6 Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.

5.2.7 Аймгийн төвийн бүх хуучин нийтийн орон сууцны гадна фасад болон дээврийн засварыг хийж, зам талбай тохижилтийн ажлыг хийнэ.

5.3 Хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгана

- 5.3.1" Сумын хөгжил "-ийн хүрээнд жишиг сумдын тоог нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 5.3.2 "Нутгийн зам" хөтөлбөр хэрэгжүүлж сумдыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлнэ.
- 5.3.3 Сумдын халуун усны газрыг шинэчилж, нийтийн ахуйн үйлчилгээний дэд бүтцийг нь сайжруулна.

5.4 Сумдад хийгдэх хөрөнгө оруулалт

Адаацаг сум: 120 хүүхдийн дотуур байр барина.

200 хүний суудалтай соёлын төвийг барина.

Баянжаргалан сум: ЗДТГ-ын барилгыг барина.

Говь-угтаал сум: Сургуулийн дотуур байр шинээр барина.

Гурвансайхан сум: 100 хүүхдийн дотуур байр шинээр барина.

Дэрэн: ЗДТГ-ын барилгыг барина.

Эрүүл мэндийн төвийн байрнд өргөтгөл хийнэ.

Дэлгэрцогт: Төрийн албан хаагчдад зориулсан 24 айлын орон сууц барина.

Дэлгэрхангай: 24 айлын орон сууц барина.

Соёлын төвд их засвар хийнэ.

Луус сум: Спорт цогцолбор шинээр барина.

ЗДТГ-ын барилга барина.

Хулд сум : ЗДТГ-ын барилгыг барина.

Өлзийт сум: Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг шийдвэрлэнэ.

Өндөршил сум: Соёл, спортын цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.

Эрүүл мэндийн төвийн барилга шинээр барина.

Сайхан-Овоо сум: 320 хүүхдийн хичээлийн шинэ байр, спорт заал барина.

Онги голын гүүрийн ажлыг барьж дуусгана.

Сайнцагаан сум: ЗДТГ болон хотын захиргааны барилга шинээр барина.

9-р цэцэрлэг шинээр барина.

2-р цэцэрлэгийг буулгаж шинээр барина.

Говийн ирээдүй цогцолбор сургуулийг шинээр барина.

Хүмүүнлэг сургуулийг шинээр барина.

"Ногоон говь" мод үржүүлгийн талбайг байгуулнаж , Мандалговь хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ..

Соёл амралтын хүлээлэн / бор овоо/-г тохижувулна.



Цагаандэлгэр сум : Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулна.

Ахуйн үйлчилгээний барилгыг ашиглатад оруулна.

Эрдэнэдалай сум: 320 хүүхдийн хичээлийн шинэ байр барина.

ЗДТГ-ын барилгыг барина.



A handwritten signature in blue ink, appearing to read 'Рамзан' (Ramzan).